



ТӨВ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/52

Зуунмод

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх Зуунмод сумын Соёл амралтын хүрээлэн болон 5-р багийн айл өрхийн суурьшлын хөрсний ус шүүрүүлэх, зайлуулах шугам татах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:

А.Зоригоо -Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга

Гишүүдэд:

Б.Батбаяр -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Ц.Нямгарав -Барилга захиалагч орон сууцны корпорацийн инженер

Д.Оюунсайхан -Иргэний төлөөлөл (Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 119 дүгээр тогтоол)

Нарийн бичгийн дарга:

Г.Ундармаа -Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Зуунмод сумын Соёл амралтын хүрээлэн болон 5-р багийн айл өрхийн суурьшлын хөрсний ус шүүрүүлэх, зайлуулах шугам татах ажлыг хуулийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (А.Зоригоо)-д, ашиг сонирхлын зөрчил, авлигаас ангид байх зарчмыг баримтлан, шуурхай зохион байгуулахыг үнэлгээний хороонд үүрэг болгосугай.

3. Энэ захирамжийн хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажиллаж, үр дүнг танилцуулахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Д.Саран-Эрдэнэ)-д, шилэн дансанд мэдээлж ажиллахыг үнэлгээний хорооны дарга (А.Зоригоо)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

4172010159